Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон

Монгол Улсын Засаг захиргаа, нутэг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хуулийнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 241 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 159,483.8 мянган төгрөгөөр буюу 1.55 хувь өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	205,701.8	342,530.8	136,829.0
Авлага	300,438.4	235,040.6	(65,397.8)
Бараа материал	29,968.0	21,565.5	(8,402.5)
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	9,688,972.8	9,785,427.9	96,455.1
Нийт хөрөнгө	10,225,080.9	10,384,564.7	159,483.8
Өр төлбөр	4,639.8	334,791.6	330,151.8

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,220,441.0	10,049,773.0	(170,668.0)
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	10,225,080.9	10,384,564.7	159,483.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас харахад мөнгөн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 342,530.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 136,829.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр / Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	205,701.7	342,530.7	136,829.0
Төгрөг	205,701.7	342,530.7	136,829.0
Төрийн сангийн харилцах	205,683.0	342,530.7	136,829.0
Арилжааны банк дахь харилцах	18.7	0.0	(18.7)
Дүн	205,701.7	342,530.7	136,829.0

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 71,690.7 мянган төгрөгийн, ОНХС-гийн данс 67,378.8 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 203,461.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

➤ Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 235,040.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 65,397.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр / Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1,291.6	13,977.6	12,686.0
Зээлийн авлага	299,146.8	221,062.9	(78,083.9)
Хувь хүмүүст олгосон зээл	299,146.8	221,062.9	(78,083.9)
Дүн	300,438.4	235,040.5	(65,397.9)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 65,397.9 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 78,083.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Тайлант онд Хоршоо Хөгжүүлэх сангаас 100,000.0 мянган төгрөгний зээл олгосон байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын данс нь оны эцэст 21,565.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 8,402.5 мянган төгрөгөөр буурсан байна

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,680.0	-	(3,680.0)
Эм боох материал	3,600.0	-	(3,600.0)
Бэлэн бүтээгдэхүүн	80.0	-	(80.0)
Хангамжийн материал	16,388.0	11,665.5	(4,722.5)
Бичиг хэргийн материал			-
Аж ахуйн материал	16,388.0	11,665.5	(4,722.5)
Түлш, шатах тослох материал			-
Бусад хангамжийн материал			-
Мал амьтад	9,900.0	9,900.0	-
Дүн	29,968.0	21,565.5	(8,402.5)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь Эмийн эргэлийн сангийн эм боох материал, ЗДТГ-ын аж ахуйн материалын дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Дүн	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 10,742,422.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 468,318.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,274,874.3	10,742,422.3	467,548.0
Барилга, байгууламж, орон сууц	3,052,359.7	3,172,359.7	120,000.0
Авто-тээврийн хэрэгсэл	103,328.2	138,670.7	35,342.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	85,679.6	133,127.1	47,447.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	17,369.4	32,527.4	15,158.0
Зам, гүүрийн байгууламж	6,847,437.4	6,847,437.4	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	168,700.0	418,300.0	249,600.0
Ном	-	-	-
Биет бус хөрөнгө	229,263.7	230,033.7	770,0
Программ хангамж	11,759.7	12,529.7	770.0
Бусад биет бус хөрөнгө	217,504.0	217,504.0	-
Дүн	10,504,138.00	10,972,456.00	468,318.00

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 468,318.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын ОНХС-гийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *ТТЗ-ийн санхүүгийн нэгтгээсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст 334,791.7 мянган төгрөг болж, оны эхнээс 330,151.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	1,039.8	186,218.1	185,178.3
Ажилчидтай холбогдсон өглөг	1,039.8	3,752.0	2,712.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	182,466.2	182,466.2
Бусад өглөг	3,600.0	148,573.6	144,973.6
Байгууллагад төлөх өглөг	3,600.0	148,573.6	144,973.6
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	4,639.8	334,791.7	330,151.9
------------	----------------	------------------	------------------

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Өр төлбөр данс оны эхнээс 330,151.9 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжүүлэх сангийн он дамжсан өр болон харъяа байгууллагуудын түлш халаалтын өрийг тайлагнасангай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

➤ *Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 10,049,773.1 мянган төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 170,668.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр /
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,009,407.2	2,009,407.2	-
Хуримтлагдсан үр дүн	6,882,486.3	6,711,818.3	(170,668.0)
Өмнөх үеийн үр дүн	6,438,273.0	6,882,486.3	444,213.2
Тайлант үеийн үр дүн	444,213.2	(170,668.0)	(614,881.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,328,547.6	1,328,547.6	-
Дүн	10,220,441.1	10,049,773.1	(170,668.0)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан нийтдээ 3,473,358.8 мянган хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 837,507.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 2,392,988.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 170,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улаанхус сум нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 3,143,875.2 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 321,592.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

орон нутгийн төсвөөс 1,887,154.5 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 803,169.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 190,092.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 380,651.2 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлогод төлөвлөсөн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 68,410.2 мянган төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,065,627.5 мянган төгрөг буюу 88.26 хувьтай байгаа нь орон нутгийн төсвийн тасарсан орлого, дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 190,092.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэнээс Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 182,321.3 мянган, Орон нутгийн хөгжүүлэх сангаас 4,771.3 мянган төгрөг тус тус орсон орлого байна.

Сумын ИТХ-ын 2024 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 07 дугаар тогтоолоор сумын 2024 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг 1,467,663.5 мянган төгрөгөөр баталж, сумын ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 07 дугаар тодотголоор 2,049,669.4 мянган төгрөгөөр буюу 582,005.9 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн суурь орлогод нийтдээ 1,887,154.5 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 162,514.9 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар тасарсан байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 69,161.7 мянган төгрөг олгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+/</u> <u>бууралт /-/</u>	<u>Дүнд</u> <u>эзлэх хувь</u>
I.Татварын орлого	2,012,419.5	1,864,195.1	(148,224.4)	85.8
II.Татварын бус орлого	37,250.0	22,959.4	(14,290.6)	61.6
Нийт дүн	2,049,669.5	1,887,154.5	(162,515.0)	92.1

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 128,112.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлогын албан татвар 4,703.7 мянган төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 1,472.0 мянган төгрөгөөр, бууны албан татвар 382.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1,145.0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 38,676.5 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төблөр 27,730.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамж 4,520.0 мянган төгрөгөөр, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 4,555.2 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 20,630.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Үйл ажиллагааны орлогын албан татвар 58,513.8 мянган төгрөг, хөрөнгө борлуулсаны орлогын татвар 650.7 мянган төгрөгөөр давж биелэгдэн, төлөвлөгөөгүй малын тоо толгойн албан татвараас 3,847.4 мянган төгрөг, бусад нэр загдаагүй орлогоос 6,340.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 13,090.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 1,887,154.4 мянган төгрөгийн татварын

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

орлого оруулж, улсын төсвөөс 321,592.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 2,153,637.5 мянган төгрөгийг зарцуулж, 3,490.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 71,690.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХурал	296,970.0	236,216.5	-60,753.4
2	Сумын ЗДТГазар	1,366,177.6	1,257,225.4	-108,952.1
3	Ахлах сургууль	314,543.6	290,259.9	-24,283.6
4	Хөх хөтөл ДСургууль	83,120.0	77,090.0	-6,030.0
5	Согоог ДСургууль	87,574.0	81,130.0	-6,444.0
6	ЭМТөв	46,577.7	43,400.0	-3,177.7
7	Хүүхдийн цэцэрлэг	36,150.8	32,810.0	-3,340.8
8	Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг	36,540.3	30,980.0	-5,560.3
9	Согоог хүүхдийн цэцэрлэг	30,145.2	15,561.0	-14,584.2
10	Соёлын төв	73,463.5	64,240.0	-9,223.5
11	Орон нутаг хөгжүүлэх сан	932,096.7	835,124.7	-96,972.0
12	Хоршоо хөгжүүлэх сан	170,000.0	101,589.8	-68,410.2
Нийт дүн		3,473,359.4	3,065,627.5	-407,731.9

Хүснэгтээс үзэхэд сумын ИТХ 60,753.4 мянган төгрөгөөр, ЗДТГ 108,952.1 мянган төгрөгөөр, Орон нутаг хөгжүүлэх сан 96,972.0 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сан 68,410.2 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлтэй холбоотой дутуу олгосон санхүүжилт, үйл ажиллагааны орлогын биелэлттэй холбоотой төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймгаас орон нутгийн төсвийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой сумын ерөнхий боловсролын 1 дүгэр сургууль 24,283.6 мянган төгрөгөөр, Хөх хөтөл багийн ерөнхий боловсролын сургууль 6,030.0 мянган төгрөгөөр, Согоог багийн ерөнхий боловсролын сургууль 6,444.0 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн төв 3,177.7 мянган төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэг 3,340.8 мянган төгрөгөөр, Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг 5,560.3 мянган төгрөгөөр, Согоог хүүхдийн цэцэрлэг 14,584.2 мянган төгрөгөөр, Соёлын төв 9,223.5 мянган төгрөгөөр тогтмол зардлын төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын баярын арга хэмжээнд 6,000.0 мянган төгрөгийн, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллого, судлагаанд 6,022.3 мянган төгрөгийн нийт 12,022.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 11,731.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 290.75 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 3 дугаар сарын 06-ний өдрийн 1/63 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,783,837.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26,757.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатны материаллаг байдлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,618,209.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 39,273.1 мянган төгрөгөөр аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор info.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 99.6 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 99.5 хувь байгаа тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн 2 байгууллага, 3 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Сумын ерөнхий боловсролын 1 дүгэр сургууль, Хөх хөтөл багийн ерөнхий боловсролын сургууль, Согоог багийн ерөнхий боловсролын сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг, Согоог хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 765,639.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 438,156.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,008.2 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 86,952.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 143,232.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас сумын ерөнхий боловсролын 1 дүгэр сургууль, Хөх хөтөл багийн ерөнхий боловсролын сургууль, Согоог багийн ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг, Согоог хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа бусад байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 4,713,512.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 553,151.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,989.7 мянган төгрөгийн төлбөрийн 4 акт тогтоож, 638,558.0 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 3,516,487.3 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт №4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Ний алдаа зөрчлийн дүн		Залруулга		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ИТХ	3	77,893.6	2	76,935.4	1	958.2	-	-	-	-
2	Сумын ЗДТГ	11	310,989.8	5	178,755.2	1	2,050.0	4	86,952.0	1	43,232.6
3	ОНХСан	3	276,755.6	2	182,466.2	-	-	-	-	-	-
4	ХХСан	1	100,000.0	-	-	-	-	-	-	1	100,000.0
Орон нутгийн байгууллагын дүн		18	765,639.0	9	438,156.8	2	3,008.2	4	86,952.0	2	143,232.6
1	Улаанхус сумын 1-р сургууль	5	3,691,603.5	2	325,947.7	-	-	1	5,026.0	2	3,360,629.8
2	Согоог сургууль	4	3,421.5	2	1,950.5	-	-	1	1,471.0	1	-
3	Хөх хөтөл сургууль	3	7,819.4	1	2,793.4	-	-	1	5,026.0	1	-
4	Улаанхус цэцэрлэг	4	32,527.5	1	25,314.0	1	2,187.5	1	5,026.0	1	-
5	Согоог цэцэрлэг	4	188,548.0	2	184,743.0	1	250.0	1	3,555.0	1	-
6	Хөххөтөл цэцэрлэг	5	191,853.1	-	-	1	2,187.5	2	33,808.2	2	155,857.5
7	Эрүүл мэндийн төв	4	597,413.7	1	12,403.2	1	364.7	1	584,645.8	1	-
8	Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад байгууллагын дүн		29	4,713,512.2	9	553,151.8	4	4,989.7	8	638,558.0	9	3,516,487.3
Нийт дүн		47	5,478,825.8	18	991,308.6	6	7,997.9	12	725,510.0	11	3,659,719.9

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй, зөрчил илрээгүй.

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 7,997.9 мянган төгрөгийн төлбөрийн 6 актыг хугацаанд нь барагдуулах, 725,510.0 мянган төгрөгийн 12 албан шаардлага, 3,659,719.9 мянган төгрөгийн 11 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах	1						1					
Дүн	1						1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								